ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2022

# ХҮН АМЫГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЖАРГАЛ*

Universal Health Coverage

HEALTH FOR ALL

## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

**Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх**

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд "Хэнийг ч орхигдуулахгүй байх"**

**Эрүүл мэндийн тэгш байдлыг хангах**

# Нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай 10 гол тусламж үйлчилгээ (ДЭМБ)



# **НЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ** бол Монгол улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний **ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ** мөн



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ, 2011.05.05

4.2.2.**Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож,** улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт түлгүүрласан байдлыг хангах;

13.2 **НЭМ-ийн тусламж үйлчилгээнд** хүн амын эрүүл мэндийн байдал (1), түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах (2), судлах (3), хянах (4), эрүүл мэндийг дэмжих (5), хамгаалах (6), өвчин эмгэгээс сэргийлэх (7), хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох (8) үйл ажиллагаа хамаарна.

| | | |
|---|---|---|
| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо - **108** | | **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ** |
| Үүнээс: | Тухайн салбарт хамааралтай хуулийн тоо -**99** | Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахад хамаарах-**29**, эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хамаарах-**15**, орчны эрүүл мэндийн хамаарах-**15**, биотехнологи, инновацийн хамааралтай-**9**, тархвар зүй, шуурхай удирдлагатай хамаарах-**6**, санхүү, аж ахуйн хамааралтай-**16**, хоол, шим тэжээлд хамаарах-**8**, нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лабораторийг хамаарах-**1**. |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо - **9** | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай зэрэг хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлдэг. |

- Өөрөөр хэлбэл "нийгмийн эрүүл мэнд"-ийн асуудал нь зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбар, тэдгээрийн албан тушаалтан, түүнчлэн бусад хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэд бүгдэд хамааралтай болох нь харагдаж байна.

-Гэтэл эрүүл мэндийн салбарын болон бусад холбогдох хуулиудад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бусад яам, агентлагуудын үүрэг оролцоо, тэдгээрийн уялдаа холбоог зохицуулж өгөөгүй байна.

Улс орнуудын сүүлийн үеийн чиг хандлага нь нийтийг хамарсан өвчний тухай бүрт тусгайлан хууль батлахаасаа илүүтэй нийгмийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй аливаа нөхцөл байдалд цаг алдахгүй, шуурхай арга хэмжээ авах, зохион байгуулалтад орох, бэлэн байдлыг хангах, нийгмийн тогтворгүй, ойлгомжгүй байдал үүсгэхгүйн тулд нийтлэг стандарт тогтоон тусгайлсан хууль батлахыг чухалчилж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг боловсруулах улс орнуудад ДЭМБ-аас "Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль" нь анагаах ухаан, хүрээлэн буй орчны тухай хууль, биоэтик зэрэг бусад салбаруудыг оролцуулсан хууль тул салбар хоорондын уялдаа холбоог хангаж, тодорхойгүй хэм хэмжээнээс зайлсхийх зөвлөмжийг хүргүүлсэн.

Улсын Их Хурлаас "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 дүгээр тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталж мөн өдрөөс эхлэн мөрдөж байна. Уг тогтоолын 2 дугаар зүйлийн "2.1.5-д Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль, эрх зүйн орчныг бий болгоно" гэж заасан.





# НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО




## "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

I үе шат 2021-2030. Эрүүл мэндийн чанар, хүртээмтэй тогтолцооны шинэчлэлийн үе
- Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгууралсан НЭМ-ийн тогтолцоо бэхэжсэн байна.

-Товлолын дархлаажуулалтыг хамралтыг нэмэгдүүлж, ВГ, сүрьеэгийн тохиолдлыг бууруулсан байна. II үе шат 2031-2040. Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх үе

III үе шат 2041-2050 Эрүүл амьдралыг дэмжих үе

2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 2.2.4.Аймаг, дүүргийн түвшинд хүн амд **нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг** байгуулна.
- 2.2.5.Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хот

Дугаар 203

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16.3, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралт, "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан) нарт даалгасугай.

3. Эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Л.ОЮУН-ЭРДЭНЭ

## Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"

- 2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр. урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ
- Эрүүл мэндийг дэмжих төв байгуулна
- Зарим аймагт ЗӨСТ, хил боомтуудад тандалтын нэгж байгуулна.

# НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ, 2011.05.05**
**15.1.6 нийгмийн эрүүл мэндийн төв;**
16.9. **Нийгмийн эрүүл мэндийн төв** нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.

Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах тухай Эрүүл мэндийн Сайдын 2020 оны 1 сарын 24-ний А/38. **"Нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрмийг батлах тухай**



**Алсын хараа 2050: 2.2.4**
**"НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ"**

- **2022** — 3 аймаг 2 дүүрэг; Хан-Уул дүүрэг
- **2023** — 8 аймаг 4 дүүрэг
- **2024** — 10 аймаг 3 дүүрэгт

ЭМ-ийн тухай хууль 11.1.3.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах

16.9.Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна

2021 оны 11-12 сард Завхан, Увс, Дорнод аймагт ЭМЯ, НЭМҮТ "Нийгмийн эрүүл мэндийн төв" байгуулах тухай хэлэлцүүлэг зохион байгуулсан.

2022 онд Орхон аймагт хэлэлцүүлэг зохион байгуулагдана.

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

**Шалгуур**: 2024 гэхэд Монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг **5 жил** болгож, урьчилан сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдах эрэгтэйчүүдийн хувь **70-д** хүрсэн байна гэсэн зорилтыг дээшүүлэн ажиллаж байна.

**Эмэгтэй 75.8** > **Эрэгтэй 66.1**

**9.7 жил**

**Дэлхийн дундаж 70.8**

**НАСНЫ ЗӨРҮҮ ДЭЛХИЙН ДУНДЖААС /4жил/ 2.5 ДАХИН ИХ БАЙНА.**

Орхон аймгийн Засг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Шалгуур: 2024 онд 73,5 болгох зорилт дэвшүүлсэн.

2020 оны байдлаар дундаж наслалт-72,34

**Эрэгтэй 71,19** < **ЭМЭГТЭЙ 82,95**

11,76



# МУ-ЫН ЗГ-ЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА




- ✓2021 оны А/360 /”Хавдрын эсрэг" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
- ✓2021 оны А/559 /”Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай/
- ✓2021 оны А/760 /“Эх, хүүхэд, НҮЭМ” арга хэмжээ/
- ✓2021 оны А/780 /”Эрүүл, идэвхтэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай/
- ✓2021 оны А/816 /Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай/

| **ӨВЧЛӨЛ /УЛС/ (10 000 хүн амд)** | **ӨВЧЛӨЛ /Орхон/ (10 000 хүн амд)** |
|---|---|
| Амьсгалын тогтолцоо 1115,74 | Амьсгалын тогтолцоо 1018,0 |
| Хоол боловсруулах тогтолцоо 1491,88 | Хоол боловсруулах тогтолцоо 1378,7 |
| Шээс бэлгийн тогтолцоо 761,22 | Шээс бэлгийн тогтолцоо 982,3 |
| Зүрх судасны тогтолцоо 903,09 | Зүрх судасны тогтолцоо 1018,0 |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант 501,34 | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант 152,7 |

| **НАС БАРАЛТ /УЛС/ (10 000 хүн амд)** | **НАС БАРАЛТ /ОРХОН/ (10 000 хүн амд)** |
|---|---|
| Зүрх судасны тогтолцоо 16,4 | Зүрх судасны тогтолцоо 21,10 |
| Хавдар13 | Хавдар13 |
| Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант 8,6 | Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант 9,0 |
| Хоол боловсруулах тогтолцоо 3,4 | Хоол боловсруулах тогтолцоо 1,8 |
| Амьсгалын тогтолцоо 1,9 | Амьсгалын тогтолцоо 2,3 |

## Эх сурвалж: Монгол улсын хавдрын өвчлөл, нас баралтын тайлан, 2021 ОН

**5981** хүн өвдөж,
**4559** хүн нас барсан.

Хавдраар оношлогдсон хүмүүсийн 60% нь
**1** жил хүрэхгүй нас барж

Хавдраар өвдсөн хүмүүсийн
**41** % нь
5 ба түүнээс дээш жил амьдарч байна

2040 он гэхэд хорт хавдрын шинэ тохиолдлын тоо 11647
, 108,7% -иар
тооцоололтой.

# 90 / 70 / 90

Хорт хавдраар өвч

**72,5%** нь
хожуу үе шатандаа оношлогдож байна.

нас

**Аймгийн хэмжээнд:**
Бүртгэгдсэн-243
Нас барсан-137
Эрт үедээ оношлогдсон хувь-34,4%

# Хорт хавдраас сэргийлэх, хянах бодлогын тэргүүлэх чиглэл

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2022

## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

- Тамхины хяналтыг сайжруулсанаар хавдрын нас баралтыг 25%-иар бууруулах
- Гепатитийн В вирус болон ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг 90%-иас доошгүй хамруулах
- Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагдалтыг 70%-иас дээш болгох
- Эрт оношлох, төгс эмчлэх
- Хорт хавдын тусламж үйлчилгээний чадавхийг бүх чиглэлээр нэмэгдүүлэх
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд шаардлагатай бүх хүнийг хамруулах




**Эдгээр хорт хавдрын эрт илрүүлгийг амжилттай хэрэгжүүлж чадвал нийт хавдрын 60% хяналтад бүрэн авч чадна.**

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар







Сүрьеэгийн өвчлөл хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан.
10 000 хүн амд. бүсээр 2010-2020 он
ДЭМБ-аас Монгол Улсыг сүрьеэгийн дарамт өндөртэй дэлхийн 30 орны тоонд оруулсан.

Хүүхдийн сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол. 2012- 2020
Нийт тохиолдлын 11,9%-ийг эзэлж, өмнөх оноос нэмэгдсэн.

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

| 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| 2.2%<br>2.3 тэрбум | 4.6%<br>3.9 тэрбум | 7.9%<br>6.6 тэрбум | 4.4%<br>4.4 тэрбум | 60.8 тэрбум |

**Эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн нийт 250 эрүүл мэндийн байгууллагаас**

**43%**




Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага

**52%**



Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад

**5%**



Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад

Өвдсөн 1 хүний эмчилгээнд
**11.2-12.3 сая**

1 хүний эрт илрүүлэгт
**56,000₮**

Монгол Улсын нийт хүн ам
3,357,542

Үзлэгт хамрагдах хүн ам /90%/
3,021,788

Цэцэрлэг, сургууль
0-18 нас
Нийт 1,244,087

Оюутан
19-24 нас
Нийт 282,339

Хөдөлмөрийн насны иргэд
25-55 нас
Нийт 1, 466,863

Тэтгэврийн насны иргэд
56-с дээш
Нийт 364,253

**60.8 тэрбум**

төгрөг Эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулагдана

**<u>Эрүүл мэндийн сайдын 2022.03.15-ны өдрийн А/139</u>**

/Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам, үзлэг, шинжилгээ, оношилгооны товлол давтамж, ерөнхий зураглал/

## НАСАНД ХҮРЭГСДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЛОЛ

- ХҮЗҮҮ ТОЛГОЙ, АМНЫ ХӨНДИЙН ЭМГЭГ
- СҮРЬЕЭ
- ЗҮРХ СУДАСНЫ ЭМГЭГ
- ХОДООДНЫ ХАВДАР
- ЭЛЭГНИЙ ХАВДАР
- БӨӨР, ШЭЭСНИЙ ЗАМЫН ЭМГЭГ
- БҮДҮҮН, ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХАВДАР
- БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР

## ХҮҮХДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЛОЛ

- БОДИСЫН СОЛИЛЦООНЫ ЭМГЭГ ӨӨРЧЛӨЛ
- ХҮҮХДИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ
- ХАРААНЫ ЭМГЭГ
- ГҮЙЛСЭН БУЛЧИРХАЙН ҮРЭВСЭЛ
- ШҮДНИЙ ЦООРОЛ
- ЗҮРХНИЙ ЭМГЭГ
- ТАРГАЛАЛТ

# Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам, үзлэг, шинжилгээ, оношилгооны товлол давтамж

Хоёр. Насанд хүрэгсдийн халдварт бус, хавдар, халдварт өвчний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний товлол, давтамж

| | № | Үзлэг, шинжилгээ, оношилгоо | 18-30 нас | 31-45 нас | 46-60 нас | 61-ээс дээш нас |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Эрсдэлийн үнэлгээ** | | | | |
| А | 1 | "Зүрх судасны өвчний нийт эрсдэл"-ийн үнэлгээ | | 40-аас дээш насанд 1 жилд 1 удаа | | |
| | 2 | "Чихрийн шижин хэв шинж 2-ын эрсдэл"-ийн үнэлгээ | | 35-аас дээш насанд 1 жилд 1 удаа | | |
| | 3 | Сүрьеэгийн үнэлгээ | 18-34 насанд 1 жилд 1 удаа | | | |
| | 4 | Сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ | 21 , 45, 60 тус тус насанд | | | |
| | 5 | Настны үнэлгээ | | | | 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй 3 жилд 1 удаа |
| | | **Эмнэл зүйн үзлэг** | | | | |
| Б | 1 | Эрүүл мэнд, бие бялдрын бүрдмэл үнэлгээ (биеийн жингийн индекс, бүсэлхийн тойрог, биеийн бүтэц найрлага тодорхойлох-яс, булчин, өөхний эзлэх хувь) | 18-аас дээш насанд 1 жилд 1 удаа | | | |
| | 2 | Артерийн даралт хэмжих | | | | |
| | 3 | Амны хөндийн үзлэг | 25-69 насанд 5 жилд 1 удаа | | | |
| | 4 | Хөхний үзлэг | 30-60 насанд 3 жилд 1 удаа | | | |
| | 5 | Нөхөн үржихүйн үзлэг | 18-25 насанд 1 жилд 1 удаа | | | |
| | 6 | Булчирхайн үзлэг | 25-49 насанд 5 жилд 1 удаа | | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | **Лабораторийн шинжилгээ** | |
| В | 1 | Биохимийн шинжилгээ (Алат, Асат, шууд билирубин, шууд бус билирубин, амилаза, креатинин, мочевин) | 18-39 насанд 3 жилд 1 удаа |
| | 2 | Өөх тосны солилцоо (их, бага нягтралтай липопротейд, холестерин, триглицерид) | 35-аас дээш насны эрэгтэй, 45-аас дээш насны эмэгтэй жилд 1 удаа<br>Эрсдэлтэй бол бүх насны хүн жилд 1 удаа<br>Эрсдэлтэй бол бүх насны хүн жилд 1 удаа |
| | 3 | Цусанд хавдрын маркер Альфа-фетопротеин (АФП) | 40-69 насанд жилд нэг удаа |
| | 4 | Цусны ерөнхий шинжилгээ | 18-39 насны бүх хүн 3 жилд 1 удаа |
| | 5 | Шээсний ерөнхий шинжилгээ | 18-39 насны бүх хүн 3 жилд 1 удаа |
| | 6 | Өлөн үеийн глюкоз | 35-аас дээш насанд 1 жилд 1 удаа |
| | 7 | Хеликобактери илрүүлэх | 35-аас дээш насанд 1 жилд 1 удаа |
| | 8 | Өтгөнд далд цус илрүүлэх | 45-аас дээш насанд 3 жилд 1 удаа |
| | 9 | Хүний папилома вирус (HPV) илрүүлэх шинжилгээ (эмэгтэй) | 35, 45 насанд 1 удаа |
| | 10 | Эсийн шинжилгээ ПАП сорил (эмэгтэй) | 30,33,36,39,42,45,48,51,54,57,60 насанд 1 удаа |
| | 11 | Гепатит С илрүүлэх хурдавчилсан сорил | 18-39 насанд 5 жилд 1 удаа |
| | 12 | Гепатит B илрүүлэх хурдавчилсан сорил | 30-44 насны бүх хүн 1 жилд 1 удаа |
| | 13 | Гепатит D илрүүлэх хурдавчилсан сорил | 30-44 насны бүх хүн 1 жилд 1 удаа |
| | 14 | Тэмбүү илрүүлэх хурдавчилсан сорил | 18-34 насны бүх хүн 1 жилд 1 удаа |
| | 15 | ХДХВ илрүүлэх хурдавчилсан сорил | 18-34 насны бүх хүн 1 жилд 1 удаа |
| | | **Багажийн шинжилгээ** | |
| | 1 | Зүрхний цахилгаан бичлэг | 40-өөс дээш насанд 1 жилд 1 удаа |
| 4 | 2 | Улаан хоолой, ходоодны дуран (хавдар, ходоодны үрэвсэлт өвчин) | 35-аас дээш насанд 1 жилд 1 удаа |
| | 3 | Цээжний рентген шинжилгээ (уушигны хавдар, сүрьеэ, уушигны үрэвсэл) | 20-34 насанд 1 жилд 1 удаа; 35-аас дээш насанд 2 жилд 1 удаа |
| | 4 | Хэвлийн ЭХО (элэг, цөс, нойр булчирхай, дэлүү, 2 бөөр, түрүү булчирхай, хэвлийн шингэн) | 40-өөс дээш насанд жилд 1 удаа, түрүү булчирхайн эхог 45-69 насанд 3 жилд 1 удаа |
| | 5 | Бамбайн хэт авиа | 40-өөс дээш насанд 5 жилд 1 удаа |
| | 6 | Хөхний хэт авиа | 40-69 насанд 2 жилд 1 удаа |
| | | **Эмчээс насны бүлгээр дүгнэх, зөвлөх** | |


ӨЭМТ-өөс урилга илгээх
Иргэн
Дурын ЭМБ-ыг сонгоно.
Эрсдэлтэй
Эрүүл
Дараа үзүүлэх товлолыг хэлж, гэрт нь буцаана.
Эмнэл зүйн заавын дагуу үзлэг, шинжилгээ, оношилгоо хийнэ.
Шинжилгээ өөрчлөлттэй бол онош тодруулахаар дараагийн шатлалд шилжүүлнэ.
Онош тодруулах шаардлагагүй бол зөвлөгөө өгнө.
Өвчтөний оношийг баталгаажуулж, мэдээллийг цахим системд бүртгэнэ.

| Өрхий эрүүл мэндийн төв. | Сум, тосгоны эрүүл мэндийн төв | Дүүргийн эрүүл мэндийн төв, НЭ | Аймгийн нэгдсэн эмнэлэг | БОЭТ | Тусгай мэргэжлийн төв | Төрөлжсөн эмнэлэг |
|---|---|---|---|---|---|---|
| 209 | 328 | 20 | 16 | 5 | 5 | 14 |

**597**

2021 онд 11 аймаг, 4 дүүрэгт Эрүүл мэндийг дэмжих төв байгуулав.

2022 онд 10 аймаг, үлдсэн дүүрэгт Эрүүл мэндийг дэмжих төв байгуулна.

ЭМДЕГ-ын сонгон шалгаруулалтад тэнцсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

2021 онд 202 эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлэг хийсэн. /55,9% нь анхан шат, 19,3% ЛШ-ын улсын ЭМБ, 24,8 хувийг ХХЭМБ, лаборатори/

# Зохион байгуулалт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2022

**Төрийн захиргааний төв байгууллага:**
- Журмыг шинэчлэх
- Эмнэлзүйн заавар батлах
- Үр дүн, зардлын үр ашиг, эрүүл мэндийн салбарт үзүүлэх үр нөлөөг үнэлэх, судлах
- Цахим

**Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар:**
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам, хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлуулах
- Үр дүнгийн талаарх мэдээллийг улсын хэмжээнд сар бүр нэгтгэн нээлттэй мэдээлэх
- Олон нийт, даатгуулагчдад ухуулан таниулах ажлыг дангаар болон хамтран зохион байгуулахыг
- Эрүүл мэндийн байгууллагыг хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллах.

**Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв:**
- Эрсдэлийн үнэлгээг хийх зааврыг боловсруулах
- Эмч, ажилтнуудад сургалт зохион байгуулах
- Эрт илрүүлэх үзлэгийн ач холбогдлыг сурталчлах
- Цахим програм хангамжийг хариуцан, шуурхай тасралтгүй байдлыг хангах

**Эрүүл мэндийн хөгжлийн төв:**
- Эмнэлзүйн заавар, аргачлалын талаар богино хугацааны сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах
- Сургалтанд ашиглах хичээл, гарын авлага, батлагдсан удирдамж, зааврын нэгдсэн санг үүсгэн, ЭМХТ-ийн веб сайтад нээлттэй байршуулах
- Анхан шатны бүртгэлийн маягтуудыг шинэчлэх, давхардлыг арилгах
- Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны тоо мэдээг цуглуулж, өдөр тутмын чанарын хяналт тавьж, нэгтгэн мэдээлэх.

**Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар:**
- Шаардагдах, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, тэдгээрийн хангамж, ашиглалт, хадгалалт, чанар аюулгүй байдалд үнэлгээ хийх
- Эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн худалдан авалт зохион байгуулах боломжийг судалж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх
- эмнэлгийн хэрэгслийн зах зээл дэх үнийн судалгааг жил бүр гаргаж, зохиомол хөөрөгдөлт бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, тогтмол хянах.

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

# Зохион байгуулалт



**Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар:**

- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амыг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, илрүүлэг үзлэгийн явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах
- Үндсэн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулах, төр, хувийн хэвшлийн ачаалал хуваалцах, ээлжийн болон цагийн хуваарийн зохицуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах
- Эрт илрүүлэх үзлэгийн тайланг хүлээн авч нэгтгэн сар бүр тайланг гарган Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх.
- Эрт илрүүлэх үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, бүртгэлийн маягт, цахим програм, хүний нөөцийн хангамж, сургалтын хэрэгцээнд үнэлгээ хийж, жил бүрийн төсөвт суулгах шаардлагатай зардлыг тооцон орон нутгийн болон эрүүл мэндийн салбарын төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх

**Гэрээт эрүүл мэндийн байгууллагууд :**

- Иргэнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт оршин суугаа газрын харьяалал харгалзахгүй хамруулах
- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн эмнэлзүйн заавар, зөвлөмжийн дагуу, өвчний учраас үйлчлүүлж буй иргэдийн тусламж, үйлчилгээг алдагдуулахгүйгээр цаг товлон зохион байгуулах
- Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгээр илрүүлсэн өвчтний оношийг баталгаажуулах, эмчлэх, хянах, дараагийн товлолт үзлэгт хамруулах зэрэг тусламж үйлчилгээний залгамж чанарыг хангах
- Цахим системд бүртгэх

**Эрүүл мэндийн даатгалын health.gov.mn системтэй холбогдсон**

**Анхан шатны эрүүл мэндийн байгууллага**

**e-hospital.mn системээр дамжуулж урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг хийх боломж бүрдсэн.**



**Маягтын дагуу цахим системд бүртгэл хийгдэж тайлан гарах боломжтой**

# ЦААШИД ХИЙГДЭЖ БУЙ АЖИЛ

1. Хүний нөөц, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн урвалж, бодисын хангамжийг нэмэгдүүлэх

2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад боломжит үзлэг, оношилгоо, шинжилгээг хийх замаар лавлагаа шатлалын эмнэлгийн ачааллыг бууруулах

3. Хүртээмж, хамралтыг нэмэгдүүлэхийн тулд явуулын амбулатори, лаборатори ажиллуулах

4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг цахим системд холбож, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, програм хангамжийг сайжруулах

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН
2022

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА